

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/68/НА-СТА-ТШЗ

Цахим www.audit.mn Орхон аймаг 2026 он	хуудас:	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: Т.Болормаа Утас: 70350757 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn
---	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.10 № 36
танай _____-ны № _____-т

УНАГА ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ОЮУНБАЙГАЛЬ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын 2025 оны А/260 дугаар захирамжаар 52,665.0 мянган төгрөгийн хөрөнгийг капиталжуулж, аймгийн болзошгүй аваарын зардлаар гүйцэтгэсэн 288,846.3 мянган төгрөгийн дээврийн засварыг бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн хүчин чадлыг 11 бүлэгтэй 275 хүүхдээр тооцсон боловч гүйцэтгэлээр 282 хүүхэд суралцаж, улсын төсвөөс 1,272,833.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлэхдээ тодруулга тайлан бэлтгээгүй, санхүүгийн тайлангийн залруулгыг тухай бүр хийж гүйцэтгээгүй, санхүүгийн программын тоон үзүүлэлтийг бүрэн татахгүй байх зэргээс шалтгаалж,

612505706

санхүүгийн тайлангийн аудит хийхэд хүндрэл үүсгэсэн.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>250,040,955.77</u>	<u>129,093,200.06</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	174,120,206.78	48,114,572.36
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	174,120,206.78	48,114,572.36
3121	Төгрөг	174,120,206.78	48,114,572.36
33	АВЛАГА	-	603,028.71
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	363,675.71
335	Бусад авлага	-	239,353.00
3351	Байгууллагаас авах авлага	-	239,353.00
35	БАРАА МАТЕРИАЛ	75,920,748.99	80,375,598.99
351	Түүхий эд материал	68,765,498.99	72,154,348.99
35110	Тусгай зориулалттай материал	68,765,498.99	72,154,348.99
354	Хангамжийн материал	7,155,250.00	8,221,250.00
35420	Аж ахуйн материал	5,064,250.00	6,865,650.00
35460	Хүнсний материал	2,091,000.00	1,355,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,485,177,872.62</u>	<u>2,698,824,509.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,485,177,872.62	2,698,824,509.55
392	Биет хөрөнгө	2,175,297,872.62	2,388,944,509.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,342,145,834.24	2,631,629,359.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(292,897,438.23)	(337,628,281.42)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	174,560,032.00	176,859,932.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(84,868,982.48)	(110,452,296.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,293,480.00	100,958,480.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(65,935,052.91)	(72,422,684.19)
393	Биет бус хөрөнгө	309,880,000.00	309,880,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	309,880,000.00	309,880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,735,218,828.39</u>	<u>2,827,917,709.61</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,735,218,828.39</u>	<u>2,827,917,709.61</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,735,218,828.39	2,827,917,709.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	309,880,000.00	309,880,000.00
51101	Өмч: - төрийн	309,880,000.00	309,880,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,552,720,608.58	1,645,419,489.80
51210	Өмнөх үеийн үр дүн	1,552,720,608.58	1,552,720,608.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	92,698,881.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	872,618,219.81	872,618,219.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,735,218,828.39</u>	<u>2,827,917,709.61</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,561,421,950.20	1,796,287,315.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	222,568,150.20	461,027,915.37
120	Нийтлэг татварын бус орлого	222,568,150.20	461,027,915.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,307,068.21	105,478,540.37
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,307,068.21	105,478,540.37
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	137,943,203.00	340,813,525.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	38,317,878.99	14,735,850.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,338,853,800.00	1,335,259,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,247,482,800.00	1,272,833,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,247,482,800.00	1,272,833,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	91,371,000.00	62,425,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	91,371,000.00	62,425,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,426,639,451.13	1,703,588,434.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,426,639,451.13	1,703,588,434.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,422,594,270.17	1,696,206,759.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	929,304,263.77	1,191,406,540.64
210101	Үндсэн цалин	611,491,093.93	649,746,600.25
210102	Нэмэгдэл	300,559,254.27	459,593,690.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,649,600.00	35,912,495.02
210104	Урамшуулал	15,604,315.57	46,153,754.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,597,986.51	149,555,105.44
210201	Тэтгэврийн даатгал	80,662,899.50	103,248,957.84
210202	Тэтгэмжийн даатгал	9,572,247.63	12,476,442.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,642,576.84	6,054,404.26
210204	Ажилгүйдлийн даатгал	4,416,052.60	5,555,061.18
210205	Эрүүл мэндийн даатгал	17,304,209.94	22,220,240.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,260,319.04	45,064,224.99
210301	Гэрэл, цахилгаан	10,791,137.88	13,326,750.62
210302	Түлш, халаалт	17,886,810.50	20,422,233.13
210303	Цэвэр, бохир ус	12,582,370.66	11,315,241.24
2104	Хангамж, бараа материалын зардал	20,789,295.00	43,668,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,395,450.00	12,934,450.00
210408	Бараа материал акталсны зардал	5,393,845.00	30,734,100.00
2105	Нормативт зардал	129,202,325.00	121,074,750.00
210502	Хоол, хүнс	129,202,325.00	121,074,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,438,500.00	9,979,700.00
210604	Урсгал засвар	50,438,500.00	9,979,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,788,800.00	3,315,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,788,800.00	3,315,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	132,212,780.85	132,142,788.07

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,345,787.00	20,243,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,822,800.00	11,024,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	100,044,193.85	100,874,538.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,045,180.96	7,381,675.01
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,045,180.96	7,381,675.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,045,180.96	7,381,675.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	134,782,499.07	92,698,881.22
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	134,782,499.07	92,698,881.22

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,385,160,868.21	1,440,737,940.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,307,068.21	105,478,540.37
120	Нийтлэг татварын бус орлого	46,307,068.21	105,478,540.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,307,068.21	105,478,540.37
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,307,068.21	105,478,540.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,338,853,800.00	1,335,259,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,247,482,800.00	1,272,833,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,247,482,800.00	1,272,833,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	91,371,000.00	62,425,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	91,371,000.00	62,425,600.00
2	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,305,836,262.28	1,564,443,674.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,305,836,262.28	1,564,443,674.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,301,791,081.32	1,557,061,999.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	929,304,263.77	1,192,009,569.35
210101	Үндсэн цалин	611,491,093.93	650,349,628.96
210102	Нэмэгдэл	300,559,254.27	459,593,690.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,649,600.00	35,912,495.02
210104	Урамшуулал	15,604,315.57	46,153,754.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,597,986.51	149,555,105.44
210201	Тэтгэврийн даатгал	80,662,899.50	103,248,957.84
210202	Тэтгэмжийн даатгал	9,572,247.63	12,476,442.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,642,576.84	6,054,404.26
210204	Ажилгүйдлийн даатгал	4,416,052.60	5,555,061.18
210205	Эрүүл мэндийн даатгал	17,304,209.94	22,220,240.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,260,319.04	45,064,224.99
210301	Гэрэл, цахилгаан	10,791,137.88	13,326,750.62
210302	Түлш, халаалт	17,886,810.50	20,422,233.13
210303	Цэвэр, бохир ус	12,582,370.66	11,315,241.24

2105	Нормативт зардал	131,293,325.00	120,339,350.00
210502	Хоол, хүнс	131,293,325.00	120,339,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,065,500.00	9,979,700.00
210604	Урсгал засвар	46,065,500.00	9,979,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,788,800.00	5,965,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,788,800.00	5,965,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,480,887.00	34,148,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,730,687.00	23,124,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,750,200.00	11,024,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,045,180.96	7,381,675.01
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,045,180.96	7,381,675.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,045,180.96	7,381,675.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>79,324,605.93</u>	<u>(123,705,734.42)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,099,900.00	2,299,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,099,900.00	2,299,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,099,900.00	2,299,900.00
222001	Тоног төхөөрөмж	1,099,900.00	2,299,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,099,900.00)</u>	<u>(2,299,900.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	78,224,705.93	(126,005,634.42)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		174,120,206.78
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	174,120,206.78	48,114,572.36

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,880,000.00	872,618,219.81	1,417,938,109.51	2,600,436,329.32
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	309,880,000.00	872,618,219.81	1,417,938,109.51	2,600,436,329.32
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	134,782,499.07	134,782,499.07
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,880,000.00	872,618,219.81	1,552,720,608.58	2,735,218,828.39
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	309,880,000.00	872,618,219.81	1,552,720,608.58	2,735,218,828.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	309,880,000.00	872,618,219.81	1,552,720,608.58	2,735,218,828.39
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	92,698,881.22	92,698,881.22
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,880,000.00	872,618,219.81	1,645,419,489.80	2,827,917,709.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,642,351,900.00	1,559,361,899.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,642,351,900.00	1,557,061,999.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,642,351,900.00	1,557,061,999.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,240,456,600.00	1,192,009,569.35
210101	Үндсэн цалин	745,005,100.00	650,349,628.96
210102	Нэмэгдэл	457,545,700.00	459,593,690.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	35,912,495.02
210104	Урамшуулал	37,905,800.00	46,153,754.90
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,724,300.00	149,555,105.44
210201	Тэтгэврийн даатгал	104,307,600.00	103,248,957.84
210202	Тэтгэмжийн даатгал	12,354,200.00	12,476,442.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,177,100.00	6,054,404.26
210204	Ажилгүйдлийн даатгал	6,177,100.00	5,555,061.18
210205	Эрүүл мэндийн даатгал	24,708,300.00	22,220,240.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,425,600.00	45,064,224.99
210301	Гэрэл, цахилгаан	12,814,100.00	13,326,750.62
210302	Түлш, халаалт	26,500,500.00	20,422,233.13
210303	Цэвэр, бохир ус	13,111,000.00	11,315,241.24
2105	Нормативт зардал	143,154,400.00	120,339,350.00
210502	Хоол, хүнс	143,154,400.00	120,339,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,979,700.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,979,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,981,500.00	5,965,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,981,500.00	5,965,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,609,500.00	34,148,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,558,700.00	23,124,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,050,800.00	11,024,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,299,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,299,900.00
222001	Тоног төхөөрөмж	-	2,299,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,642,351,900.00	1,440,737,940.37
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,430,394,900.00	1,272,833,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,430,394,900.00	1,272,833,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,425,600.00	62,425,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	62,425,600.00	62,425,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	149,531,400.00	105,478,540.37
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	149,531,400.00	105,478,540.37
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		174,120,206.78
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		48,114,572.36

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,338.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн 363.7 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгуулсан.
- Тайланд онд төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж худалдан авсан 2,299.9 мянган төгрөгийн зардлыг буруу тайлагнасан байсныг залруулсан.
- Тайланд онд 1,300.0 мянган төгрөгөөр эй ай ханын зураг, 375.0 мянган төгрөгөөр чихэвч худалдан авч шууд зарлагадсан байсныг тусгай зориулалтын бараа материалын дансанд үлдэгдлээр тайлагнуулсан.

Аудитаар нийт 3,117.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, худалдан авах ажиллагаатай холбоотой 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,117.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт: Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

3.2 Албан шаардлага

Тайланд онд хүнсний материалын зардлыг 5-6 багц болгон худалдан авах ажиллагаа зохион байгуулах ёстой байтал шууд худалдан авалт хийж, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тодруулга тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад бэлтгэж ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-т "санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025-01-03-ны өдрийн А/З тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх зааврыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж байх.

2. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цэцэрлэгийн хүүхдийн ирцийг, хоолны зарцуулалттай тулгахад тогтоосон нормоос бага буюу 3,117,650 төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоолоор батлагдсан "цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох" журмын 1-т "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 3,000 (гурван мянга) төгрөгөөр, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг болон уртасгасан цагаар ажиллах бүлэгт хамрагдаж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 4100 (дөрвөн мянга нэг зуун) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цэцэрлэгийн хүүхдийн өдрийн хоолны зардлыг тогтоосон нормын дагуу тооцож, олгох.

3. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд эрхлэгчийн тушаалаар нярав солигдоход эд хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Эд хариуцагч солигдох үед эд хөрөнгийн тооллого хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нийгмийн даатгалын шимтгэлийн 363.7 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгуулсан.	1	363.7	1	363.7								
Тайланд онд төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж худалдан авсан 2,299.9 мянган төгрөгийн зардлыг буруу тайлагнасан байсныг залруулсан.	1	2,299.9			1	2,299.9						
Тайланд онд 1,300.0 мянган төгрөгөөр эй ай ханын зураг, 375.0 мянган төгрөгөөр чихэвч худалдан авч шууд зарлагдсан байсныг тусгай зориулалтын бараа материалын дансанд үлдэгдлээр тайлагнуулсан.	1	1,675.0			1	1,675.0						
Дүн	3	4,338.6	1	363.7	2	3,974.9						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад бэлтгэж ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.	1	-					1	-				
Цэцэрлэгийн хүүхдийн ирцийг, хоолны зарцуулалттай тулгахад тогтоосон нормоос бага буюу 3,117,650 төгрөгөөр дутуу зарцуулсан байна.	1	3,117.6					1	3,117.6				

Тайлант онд эрхлэгчийн тушаалаар нярав солигдоход эд хөрөнгийн тооллого хийгээгүй байна.	1					1	-			
Тайланд онд хүнсний материалын зардлыг 5-6 багц болгон худалдан авах ажиллагаа зохион байгуулах ёстой байтал шууд худалдан авалт хийж, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.	1	-			1	-				
Дүн	4	3,117.6			1	-	3	3,117.6		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хяагаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

